



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/625

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмадын байгууллагын ажлыг дэмжин, ахмадуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зүтгэл гарган, үр бүтээлтэй ажилласан Мянгад сумын ахмад настан Жигжидийн Бат-Очир, Готовын Баасансүрэн, Балганы Нямаа, Окоогийн Чулуун нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 120 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 120 000 төгрөг /нэг зуун хорин мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

